

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн товч танилцуулгыг дараах байдлаар бэлтгэн танилцуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн үйлчлэх хүрээ, нийтлэг агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвшөөрөлд мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим, зөвшөөрлийн эрсдэлийн түвшинг “өндөр, дунд, бага” гэж ангилан, эрсдэлийн түвшин бага, нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд эрхлэх, ахуйн хэрэгцээний зориулалтаар эрхлэх үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх, түүний хугацаа, мэдэгдлийн хэлбэрийг тогтоох, тодорхойлох хуудасны загварыг боловсруулах, батлах, хяналт тавих, мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны журам, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг хуулийн төсөлд нэмж тусгалаа.

Зөвшөөрлийн шинжтэй мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй бөгөөд шинээр оруулж буй хуулийн зохицуулалт болно.

Зөвшөөрлийн тухай хууль болон бусад салбар хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүн, зөвшөөрөл тус бүрд хийсэн зураглал, зөвшөөрөл олгож байгаа яам, төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээ, тайлан, гадаадын зарим улс орны зөвшөөрөлтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг судалсны үндсэн дээр хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн төлөөлөлтэй 17 удаагийн уулзалт, ярилцлага, Зөвшөөрлийн тухай хуулиар эрх олгосон 13 чиглэлээр зөвшөөрөл олгож байгаа эрх бүхий этгээдтэй уулзалт, хэлэлцүүлгийг хийж, тэдний саналыг хуулийн төсөлд тусгалаа.

Мөн гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг мэргэжлийн судлаач, зөвлөхүүдээс бүрдсэн хөндлөнгийн багаар гүйцэтгүүлсэн.

Олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн зөвшөөрлөөс гадна мэдэгдлээр хийх үйл ажиллагааг тусгасан байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулиар нэг удаагийн шинжтэй, эхлэх, дуусах хугацаатай, ахуйн хэрэгцээнд зориулан хийх эрсдэлийн түвшин багатай зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр хийх нийтлэг харилцааг зохицуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт цахим хуудсанд байршуулж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

---o0o---